



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/699

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3 "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэхь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шинээр гарсан болон сэргээн засварласан гүн өрмийн худгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүний нөөц, дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны Бэлчээр, тэжээл усан хангамж хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга


Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин аялал жуулчлалын Усны нөөцийн ашиглалт хамгаалалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

Сумдын ажлын хэсэг (Сумын Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн сангийн төлөөлөгч, Мал эмнэлэг үржлийн тасгийн усан хангамж хариуцсан мэргэжилтэн)

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргасан гүн өрмийн худгийг нэг бүрчлэн газар дээр нь үзэж, журмын дагуу ашиглалтад хүлээн авах ажлыг зохон байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүний нөөц, дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД 1101525